



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/СЗБ

Алтай хот

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.18 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Эрмүүн Энто” ХХК-ийн Энто Эки эмэгтэйчүүдийн клиникт эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгосугай.

2.“Амин дэм Алтай” ХХК-ийн Амин дэм эмийн сан, “Ариун тан Алтай” ХХК-ийн Ариун тан эмийн сан, “Мөнхийн шидэт тун” ХХК-ийн Мөнхийн шидэт тун эмийн сангийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хугацааг тус бүр 5 жилийн хугацаатай сунгасугай.

3.Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс (Б.Алтайбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Г.Гантулга), Эрүүл мэндийн газар (Ц.Туяа)-т тус тус үүрэг болгосугай .

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ

C:/My Documents/ZAHNR-3A-4 doc

0201001710